



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/38

Баянбулаг

Мал тарилгын ажил зохион
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8 1,2, 9.9, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/202 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 15 –ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 20 –ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Вакцинжуулалтын ажлыг график гарган голомтыг үндэслэн технологийн хугацаанд нь ажиллах хүн хүч, зөөврийн хашаа, машин техник нөөцөө бүрдүүлж чанартай хийж гүйцэтгэхийг “БЭЭЭЭГ” Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч Д.Эрдэнэсүвд, “Дэлгэрэх Баян сав” Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч Ю.Гаамаа нарт үүрэг болгосугай.

3. Малчдад зар мэдээ хүргэж бүрэн хамруулж ажиллахыг багуудын Засаг дарга нарт даалгасугай.

4. Мал эмнэлгийн тасгаас вакцинжуулах ажлыг товлосон хугацаанд нь мал, сүргээ бэлэн байлгаж, барьж бэхлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах, мал сүргээ бүрэн хамруулахыг малчдад даалгасугай.

5. Захиалгат вакцин, эм био бэлдмэлийг хугацаанд нь татан авч мал эмнэлгүүдэд хуваарилан өгч тарилгын явцад байнгын хяналт тавьж Засаг дарга, Аймгийн Мал эмнэлгийн газарт цаг тухайд нь мэдээллэж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Б.Батхонгорт үүрэг болгосугай.

ДАРГА:  Н.ГАНСҮХ



642301069